ТУЗ-ийн гишүүдийн анхдугаар хуралдаан болж ТУЗ-ийн даргаар Н.Буянхүүг гишүүдийн 100 хувийн саналаар сонгов.

ТУЗ-ын дарга Н.Буянхүү Хувьцаа эзэмшигч та нөхдийн итгэл найдварыг биелүүлж ажиллахаа мэдэгдье. Манай компани нь өөрийн хөрөнгийн дутагдалтайгаас үр ашигтай ажиллаж чадахгүй байгааг бид бүхэн мэдэж байгаа. Энэ үндсэн хөрөнгөнүүдээс аль нэгийг нь худалдан борлуулж эргэлтэнд оруулахгүй бол цаашид үйл ажиллагаа явуулж чадахгүй болоод байна. Иймд 3500 м2-ын агуулах, конторын барилгыг худалдан борлуулах шийдвэрээ цаашид үргэлжлүүлэх эсэх талаар та нөхдийг байр сууриа илэрхийлж шийдвэр гаргаж өгнө үү гэж хүсэх байна.

Х.Төмөрсумъяа: Агуулахын барилгаа худалдана гээд нилээд хугацаа өнгөрлөө. Үр дүн гараагүй байна. Тэгэхээр аль нэг үндсэн хөрөнгөө худалдан борлуулж эргэлтийн хөрөнгийн эх үүсвэртэй болох эрхийг ТУЗ-д олговол болох уу? ТУЗ судалж үзээд гүйцэтгэх удирдлагад эрх олгох нь зөв байх.

Х.Нарантуяа: Ямар үндсэн хөрөнгөө худалдахаа шийдэх эрхийг ТУЗ-д үүрэг болгоё.

Өөр санал хэлэх хүн гараагүй тул дээрх хүмүүсийн саналаар үндсэн хөрөнгө худалдах эрхийг ТУЗ-д олгох эсэх талаар илээр санал хураалт явуулав. Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар ҮХХөрөнгө худалдан борлуулах талаар шийдвэр гаргах эрхийг ТУЗ-д олгохоор болов.

Шийдвэрлэсэн нь:

1. Компани нь алдагдалтай ажиллаж байгаа учир ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн шийдвэрийг батлав.
2. ҮХХөрөнгө худалдан борлуулах талаар шийдвэр гаргах эрхийг ТУЗ-д олгохоор шийдвэрлэв.
3. ТУЗ-ийн гишүүдэд Н.Цоож, Н.Буянхүү, Д.Мөнх-Очир, Г.Эрдэнэбаатар, Б.Ганбаяр, Ц.Энхтуяа, П.Аюусэд, Х.Төмөрсумъяа, Н.Баярсүрэн нарыг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар сонгож батлав.
4. Хувьцаа эзэмшигчдийн гаргасан санал, зөвөлгөөг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж хүнсний дэлгүүр болон жуулчны баазыг өргөтгөж олох орлогын хэмжээг нэмэгдүүлэх, сул чөлөөтэй өрөө тасалгааны ашиглалтыг